



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

140 /140/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.22

## ҮЙЛ ЯВДАЛ

### У.Хүрэлсүх: НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧДЫН ТООГ НЭМЖ, 15 ХУВЬД ХҮРГЭНЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх энэ сарын 20-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррештай уулзсан бөгөөд энэ үеэр Монгол Улс НҮБ-д гишүүнээр элссэний түүхт 60 жилийн ойгоор НҮБ-ын Ерөнхий ассамблейн 76 дугаар чуулганд оролцож байгаадаа баяртай байгаагаа илэрхийлж НҮБ, түүний системийн байгууллагууд Монгол Улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг чухал түнш гэдгийг онцлон тэмдэглэв. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын дэмжлэг, хамтын ажиллагааг өндөрөөр үнэлдэг бөгөөд ялангуяа цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг тууштай дэмжиж, хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлээд Монгол Улс НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд дахь оролцоогоо өргөжүүлэх бодлого баримталж, НҮБ-ын чадавхын

бэлэн байдлын системд цэргийн дөрвөн нэгж бүртгүүлснийг онцолсон юм. Мөн цэргийн багуудаа ойрын хугацаанд илгээх сонирхолтой байгаа тухай болон Тавантолгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийг түшиглэн “Энхийг дэмжих ажиллагааны олон улсын хүрээлэн” байгуулах саналыг Энхийг сахиулах үйл ажиллагааны асуудлаарх санаачилгынхаа хүрээнд дэмжинэ гэдэгт найдаж байгаагаа тодотгов. Мөн Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолын дагуу НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог нэмж, 15 хувьд хүргэх чиглэл баримталж байгаа бөгөөд энэ дагуу энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын оролцооны талаар бүс нутгийн орнуудын олон улсын хурлыг ирэх онд Улаанбаатар хотод зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг хүслээ.

## Түүхэнд энэ өдөр

2008 он:

Монгол-Туркийн Тусгай хүчний цэргийн багтай хамтарсан “НҮҮДЭЛЧИН ДАЙЧИД-2008” хээрийн хамтарсан сургалт, дадлагыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулав.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
17	1
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
35	23

## “СЭЛЭНГЭ-2021” ГАРААНААС ГАРЛАА

Монгол Улс, ОХУ-ын хамтарсан “Сэлэнгэ-2021” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн нээлтийн ажиллагаа яг одоо дугаар шилжих мөчид Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Сургалтын төвийн районд зохион байгуулагдаж байна.

Нээлтийн ёслолын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Дорнодын цэргийн тойргийн командлагчийн орлогч, дэслэгч генерал М.Я.Носулев, Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар нарын бусад албаны хүмүүс оролцож байна.

10 дугаар сарын 5-ны өдөр хүртэл үргэлжлэх “Сэлэнгэ-2021” сургууль нь “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулж явуулах” сэдвээр явагдах бөгөөд Монголын талаас сургуулийн удирдагчаар Зэвсэгт

хүчний ХЗЦК-ын Штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, ОХУ-ын талаас Дорнодын цэргийн тойргийн 36 дугаар армийн командлагчийн үүрэг гүйцэтгэгч,

хошууч генерал И.Б.Тимофеев нар үүрэг гүйцэтгэж байна. Мөн Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудаас хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын батальон оролцож байгаа юм.

“Сэлэнгэ-2021” сургуулийн нээлтийн ажиллагааны дэлгэрэнгүй сурвалжилгыг маргаашийн “Соёмбо-Мэдээ” өдөр тутмын цахим сониноор хүргэх болно.



## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,350.0	3,360.0
CNY	441.00	441.08
RUB	38.20	39.40
JPY	25.76	26.20
KRW	2.38	2.47

## ЗУРХАЙ

2021.09.22 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 17/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ДӨРВӨН НОГООН ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

## БИД МАРТАХ УЧИРГҮЙ ...



Зэвсэгт хүчний 100, Чөлөөлөх дайны ялалтын 76 жилийн ой, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штаб, “Эх орны дайчид” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага хамтран Нийслэлийн дүүрэг, хороонд амьдарч буй дайн, байлдаанд оролцсон нийслэлийн зургаан дүүрэгт амьдарч буй 28 ахмад дайчиндаа хүндэтгэл үзүүлж байна.

Тодруулбал, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 онд улсын баруун хилд болсон зэвсэгт тулгаралтад оролцож түүхэн гавьяаг байгуулсан ахмад

дайчдад ийнхүү хүндэтгэл үзүүлж буй юм.Энэхүү хүндэтгэлийн ёслолыг цар тахлын хүнд нөхцөлд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр ахмад дайчдынхаа амьдарч буй орон сууцны орцны гадна болон гудамжинд нь зохион байгуулж байгаа юм.

Ёслолын үеэр дайнд оролцсон нэгтгэл, ангийн Байлдааны тугийг ЗХЖШ-ын үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн аялгуу дор хүндэтгэлтэйгээр залж, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид болон үлээвэр найрал хөгжимчид урлагийн мэндчилгээ дэвшүүлж байгаа юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 274,992 +2,543	ЭДГЭРСЭН 273,805 +4,883	НАС БАРСАН 1059 +13
------------------------------------	----------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5076 +87	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 203	ЭДГЭРСЭН 4777
-----------------------------	----------------------------	------------------

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

<b>Тохиолдол</b> Нийт: 229,845,805
<b>Эдгэрсэн</b> Нийт: 206,523,668
<b>Нас барсан</b> Нийт: 4,713,875

Үс засуулбал:  
Өнгө зүс доройтно  
Наран ургах, шингих:  
06.39-18.51  
Барилдлага:  
Рашаан  
Шүтэн барилдлага:  
Авахуй  
Суудал:  
Шороо

Аргын тооллын 9 сарын 22, Буд гараг. Билгийн тооллын 17, Дэлгэрүүлэгч одтой, харагчин тахиа өдөр. Өдрийн наран 6 цаг 39 минутад мандан, 18 цаг 51 минутад жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, лусыг тахиx, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулаx, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэтгэй газар очих, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одоосод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Балжинням, Дашнямтай өдөр. Намрын хугас дунд болох улирал (4 цаг 43 мин)-д эхэлнэ.

Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Үйл явдал

(Түрүүч нь I нүүрт)



Ахмад дайчин Д.ЦАНЖИД:



Ахмад дайчин Т.БАДАРЧ:

хүүхдүүд бидний хувьд сэтгэл өндөр байна. Аав маань 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож Жэхэ хот хүрсэн эрэлхэг гавьяат дайчдын нэг. Тухайн үед бичиг үсэг мэддэг хүн тун ховор байсан тул хээрийн штабт дарга нарын нарийн бичгээр болон нууцын хэлтэст ажиллаж байсан гэдэг. Цэрэгт явахдаа намын гишүүн болчихсон байсан. Дайнд оролцсон хэдэн хөгшчүүл маань тэр бүр гадуур явж чадахгүй шүү дээ. Та бүхнийг ирэхээс өмнө аавд энэ үйл ажиллагааны талаар дуулгахад сэтгэл нь маш их хөдөлсөн. Залуучууд ирж байна гэнэ үү гээд цаг тутам л шалгаагаад байсан. Маш сайхан хүндэтгэл үзүүлээ. Та бүхэндээ баярлалаа.

Ахмад дайчин Г.Баарай гуайн хүү Д.БАТАА:



-Та бүхэндээ маш их баярлалаа. Манай гэр бүлийн зүгээс сэтгэл маш өндөр байгааг илэрхийлэе. Манай ээж 1945-1949 онд Ховдын Байтагбогдод цэргийн сувилал, тогооч зэрэг ажлыг хийж явсан. Өнөөдөр 93 насныг зооглож байна. Өнөөдрийн үйл ажиллагааны дараа манай хорооны оршин суугчид ээжээр минь бахархаж явдгаа илэрхийллээ. Бидний сэтгэлд тод үлдэх үйл явдал боллоо. Дахин дахин баярлалаа.



Миний хүүхдүүд цэрэг армия улам өндөрт өргөж яваарай. Өөрсдийнхөө эрүүл мэндийг бодож, өвөөгийнхөө насыг аваарай. Өнөөдөр би 97 настай. Миний эх орныхоо төлөө оруулсан өчүүхэн хувь нэмрийг үнэлж энэ үйл ажиллагааг зохион байгуулсан Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд баярлаж байгаагаа хэлэе.

Ахмад дайчин Ж.Ичинноров гуайн хүү И.ГАНБОЛД:

-Батлан хамгаалах Зэвсэгт хүчнээс өнөөдөр аавд минь зориулж энэхүү үйл ажиллагааг зохион байгуулж байгаад үр



Хамгийн хүнд нь "Мэргэн уулын тулалдаан" хэмээн алдаршсан, өглөө 9-өөс орой 9 цаг хүртэл тулалдсан зэвсэгт мөргөлдөөн байсан. 1945 оны 6 дугаар сарын 2-ны өдөр БНМАУ-ын баатар С.Лхагвадорж тэнд баатар цол хүртэж чадалгүй амь эрсдэж байлаа. Миний байгуулсан гавьяа бол эх орныхоо төлөө өргөх өчүүхэн зүйл юм шүү. Үүнийг минь үнэлж ирсэн та бүгдэд баярлалаа. Үйлс бүхэн тань өндөр байх болтугай.

ЦЭРГИЙН АЛБА ХЭВШҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Тус анги нь 2021 онд УБХИС-ийг төгсөж шинээр албан тушаалд томилогдон ирсэн офицер, ахлагч нарын цэргийн ерөнхий бэлтгэл болон бие бялдрын түвшнийг тогтоох, томилогдсон ажлын байрны онцлог, тэдгээрт тавигдах шаардлагын талаар ойлголт өгөх, албан

тушаал, гүйцэтгэх үүрэгт нь богино хугацаанд сурган дадлагажуулж салбар, нэгжийн бүрэлдэхүүнд жигдрүүлэх ажлыг ангийн байрлалд 2021 оны 9 дүгээр сарын 13-24-ний өдрийн хооронд зохион байгуулж байна.

Томилогдсон 4 офицер, 8 ахлагчтай "Шинээр томилогдсон офицер ахлагч нартай

цэргийн алба хэвшүүлэх сургалт"-ын хөтөлбөр боловсруулан 10 хичээлийг 61 цагт багтаан сургалтыг амжилттай зохион байгуулж байна. Сургалтын төгсгөлд тактик, тусгай тактик, мэргэжлийн бэлтгэл, галын бэлтгэл, биеийн тамир, хууль эрх зүй гэгсэн хичээлүүдээр шалгалт авч, томилогдсон салбарт нь явуулах юм.

Ахмад З.АНХБАЯР

ВАРРАП МУЖИЙН ВАУ ХОТОД БАЙРЛАХ БАРУУН БҮСИЙН ШТАБТ АЙЛЧИЛЛАА



Меашо Хагос Сеюум болон түүний штаб зочдыг найрсаар хүлээн авч ажиллагааны газар орон болон штабын үйл ажиллагааны танилцуулга хийж ажлын онцлог, дэвшилтэт арга барилын талаар харилцан туршлага солилцов.

НҮБ-ын Баруун бүсийн хариуцсан дарга ноён Сэм Мухумур, бригадын генерал Б.Эрдэнэбатыг хүлээн авч уулзан нөхөрсөг, ажил хэрэгч яриаг өрнүүлсэн. Түүнчлэн НҮБ-ын баазад байрлах Бангладеш Улсын мотобуудлагын батальон, БНХАУ-ын инженерийн ротын үйл ажиллагаатай танилцлаа.

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны Жуба бүсийн командлагч, бригадын генерал Б.Эрдэнэбатын штабын зарим бүрэлдэхүүн ажиллагааны газар оронтой танилцах, бусад бүсийн хариуцлагын бүс, ажиллагааны онцлогтой танилцан, туршлага судлах зорилгоор ажлын айлчлалуудыг төлөвлөсний дагуу Варрап мужийн Вау хотод байрлах Баруун бүсийн штабын үйл ажиллагаатай танилцахаар 9 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд айлчлав.

Баруун бүсийн командлагч Этопи Улсын бригадын генерал

Сэрэмжлүүлэг

ГАЗАР ХӨДЛӨЛТ

Газар хөдлөлт гэдэг нь дэлхийн царцдас хэмээх чулуулаг давхаргаас тогтох хавтангуудын шилжих хөдөлгөөний дүнд болон мантын дээд хэсэгт гэнэт дэлбэрэлт болсны улмаас үүсэн бий болсон хэлбэлзэл хол зайд дамжин шилжсэний үр дүнд үүсдэг газар доорх түлхэлт буюу дэлхийн гадаргуугийн хэлбэлзэл юм. Энэ нь учруулах хор уршиг, хөнөөл ихтэй, урьдчилан таамаглах боломжгүй, гэнэт асар богино хугацаанд үүсдэг хамгийн аюултай байгалийн хүчин зүйл бөгөөд үүнээс үүсэх хор хохиролтой тэнцэх гамшиг бараг байхгүй юм. Жил бүр хэдэн сая маш бага хүчтэй газар хөдлөлүүд болж байдаг бол 150 мянган сул, 19 мянган дунд, долоон мянга орчим хүчтэй, 150 орчим сүйтгэгч хүчтэй газар хөдлөлтүүд болдог ажээ.

Үүсэх шалтгаан нь байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой. Байгалийн гаралтай газар хөдлөлт нь байгалийн хүчний үйл ажиллагааны дүнд үүсдэг ба дэлхийн царцдасны тектоник хөдөлгөөн, галт уулсын дэлбэрэлт, хүчтэй цасны нуранги, хөрсний гулсалт, ан цав үүсэх, солир унах, дэлхий сансрын том биетүүдтэй мөргөлдөх зэргээс, хүний үйл ажиллагаатай холбоотой нь маш хүчтэй дэлбэлэлт хийх, газар дор инженерийн байгууламж, гадарга дээр их хэмжээний усан сан байгуулах, ойр зайтай асар олон давхар барилга байшин барих, ашигт малтмал олборлох зэргээс үүдэлтэй.

Газар дор цохилт бий болж буй хэсгийг газар хөдлөлтийн голомт гэнэ. Энэ нь хэдэн арван метрээс хэдэн зуун км хүртэл янз бүрийн гүнд үүсэж болох агаад голомтын төвийг гипоцентр, түүний газрын гадаргуу дээрх проекцыг эпицентр гэнэ. Эпицентр болон түүний ойр орчмын газар нутгийг плейсто чичирхийллийн бүс гэдэг. Энэ бүсэд газар хөдлөлтийн хүчний үзүүлэх нөлөө их учраас хамгийн их хэмжээний гамшиг учруулдаг байна. Газар хөдлөлт нь чичирхийллийн долгионыг үүсгэдэг. Энэ нь голомтоос 2-8 км/цагийн хурдтайгаар тал бүр тийш тархаж гол хор хөнөөл учруулдаг хүчин зүйл нь бөгөөд түүнийг сейсмограмм гэдэг тусгай багажаар хэмждэг аж.

Өнгөрсөн 4000 жилд манай дэлхий дээр 13 сая гаруй хүн газар хөдлөлтийн улмаас амь насаа алджээ. Газар хөдлөлтийн аюултай бүсэд долоон балл түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт болдог газар нутаг хамаардаг хийгээд энэ бүсэд дэлхийн хүн амын бараг тэн хагас нь амьдарч, хот суурингийн 70 орчим хувь нь оршдог байна. Монгол улсын хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт, 12 сум, суурин газар газар хөдлөлтийн есөн баллаас дээш баллын бүс нутагт оршиж байна. Ийм учраас хүчтэй тооцогддог газар хөдлөлт олон удаа болж байсан ба жилд дунджаар 1000-1500 удаагийн газар хөдлөлт бүртгэгдэж байгаагаас 3-5 удаа мэдрэгдэм хүчтэй газар хөдлөлт болдог байна. Үүнээс энэ онд 2600 гаруй удаагийн газар хөдлөлт бүтэгджээ. Магнитудын таван баллаас дээш хүчтэй газар хөдлөлтийг аюултай үзэгдэл гэж үздэг байна.

1957 онд Говь-Алтай аймгийн Гурван богд сумын нутаг дэвсгэрт маш хүчтэй буюу 11-12 баллын хүчтэй газар хөдлөлт болж, монгол улсын бүх газар нутагт мэдрэгдсэн бөгөөд Улаанбаатар хотод таван баллын чичирхийлэл мэдрэгджээ. Тухайн цаг үед манай орны хүн амын нягтрал бага, таруу суурьшилтай ихэвчлэн гэрт амьдардаг байсан тул газар хөдлөлтөөс учрах хохирол харьцангуй бага байсан бол одоо цагт ихэнх нь төв суурин газарт суурьшиж, байшин барилгад амьдрах болсноор газар хөдлөлтийн гамшигын талаар онцлон анхаарч, урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга

ажиллагаанд суралцах, дадлагажих зайлшгүй шаардлага тулгарч байна.

Газар хөдлөлтийн улмаас учрах хохирлын хэмжээ нь хүн амын нягтаршил, ялангуяа барилга, байгууламжийн чанар байдал, газар хөдлөлтийн тэсвэршилт, энэ талаарх олон нийтийн дундах мэдлэг, мэдээлэл, хийгдсэн сургалт бэлтгэлийн түвшин, эрэн хайх, аврах ажиллагааны бэлэн байдал, ур чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална.

Газар хөдлөлтийг долгион хэлбэртэй болох тухай анхны санааг 18 дугаар зууны дунд үед Америкийн одон орон судлаач, математикч профессор Д. Уинтроп дэвшүүлжээ. Тэрээр байнга чичирхийлэл болж байдаг гэдгийг тогтоосон ба үүнээс улбаалан 1902 онд дэлхий даяар чичирхийллийг хэмжих станцуудыг байгуулж, судалгаа явуулж эхэлсний үр дүнд дэлхийн тектоник хавтангуудын нийлсэн тэр хэсэгт чичирхийллийн аюул өндөр байдаг нь тогтоогдсон байна.

Дэлхийн гадаргуу магмын гадаргуу дээр наалдаж байдаг салангид хавтангуудаас тогтодог ба эдгээр нь хоорондоо түлхэлцэж, мөргөлдөж, нэг нэгэндээ үйлчлэл үзүүлснээр газар хөдлөлт үүсдэг бөгөөд хамгийн хөнөөл ихтэй, байнга давтагддаг газар хөдлөлт нь дээр дурдсан байдлаас болон дэлхийн дотоод бүтэцэд дэлбэрэлт болсноос үүсэх тектоник газар хөдлөлт юм. Бүх газар хөдлөлтийн 90 хувийг ийм хэлбэрийн газар хөдлөлт эзэлдэг ажээ.

Газар хөдлөлтийн хүчийг ихэнх улс орнуудад хэрэглэгдэх Меркаллийн шаталбар ашиглан хэмжинэ. Газар доорх анхны түлхэлт ердөө хэдхэн секунд л болдог.Түүний дараа сүүлчийн түлхэлт буюу афтершок ажиглагддаг. Түлхэлтүүдийн хоорондын хугацаа хэдхэн секунд, минут, цаг, хоног байж болдог. Ихэнхдээ 5-20 секундэд үргэлжилсэн чичирхийллийн дараа газар доорх түлхэлт нэмэгдэж улмаар барилга, байгууламж нурж эхэлнэ. Чичирхийлэл хэчнээн удаан үргэлжилнэ төдий чинээ их эвдрэл сүйрэл гарна. Үүний зэрэгцээ дэлхийн гүнээс тар няр хийсэн дуу чимээ гарч газрын гадаргуу дээр асар өргөн, үргэлжилсэн ан цав үүсэж, хөрсний бүтэц өөрчлөгдөн хөрсний гулсалт, нуранги үүснэ.

Газар хөдлөлт нь асар богино хугацаанд буюу хэдхэн минутад бүхэл бүтэн том хотыг сүйтгэж, байгаль орчны төлөв байдлыг өөрчлөн, олон хүнийг гэмтээж, амь насыг нь сүйтгэж, асар их хэмжээний хохирол учруулдаг байна. Хэрвээ голомтын дээд хэсэгт их хэмжээний ус байвал цунами үүснэ. Цунами нь мөн л адил эрэг орчмын газар нутгийг сүйтгэх аюултай юм. Газар хөдлөлтийг сул /1-4/ балл, хүчтэй /5- 7/ балл, маш хүчтэй /8 ба түүнээс дээш балл / гэж ангилна.

Газар хөдлөлтийн үед анхдагч, хоёрдогч хөнөөх хүчин зүйлүүд үүсдэг. Анхдагч хөнөөлийн үед барилга, байгууламжийг нураах, газрын гадаргууд өөрчлөлт оруулах хүчин зүйл үйлчлэх бөгөөд хоёрдогч үед гал түймэр гарах, нэн шаардлагатай системүүд тасалдах, үер, үйлдвэрийн осол, хөрсний гулсалт, нуруулт үүснэ. Үүний нөлөөгөөр онцгой байдал үүсдэг байна.

Барилга, байгууламж нурснаас болж хүмүүс нурангид дарагдаж гэмтэх, гал түймэрт өртөх, усанд автах зэрэг болон бусад олон шалтгаант байдлаар амь насаа алдах аюултай нөхцөл байдал бий болдог байна. Энэ байдлаас сэргийлэхийн тулд хүмүүс газар хөдлөлт тасалдах, үер, үйлдвэрийн осол, хөрсний газар нутаг зэргийг нь урьдчилан тодорхойлох арга замыг олохыг чармайн оролдож байгаа боловч харамсалтай нь олоогүй байна.

/үргэлжлэл нь дараагийн дугаарт/